



НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА Х.БОЛДБААТАР
ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2015.03.17 № 03/2013

танай _____-ны № _____-т

Хуулийн хэрэгжилтийг хангуулах
тухай

Авлигатай тэмцэх газрын даргын баталсан удирдамжийн дагуу Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх болон Судалгаа шинжилгээний албанаас томилогдсон ажлын хэсэг 2015 оны 2 дугаар сарын 25-наас 2015 оны 2 дугаар сарын 27-ны өдрүүдэд Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс байгууллагуудын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцлаа.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцахад дараах зөрчил, дутагдал илэрсэн. Тухайлбал,

1/ дүүргийн удирдах албан тушаалтнууд өөртэйгээ холбоотой шийдвэр гаргах, хяналт шалгалт хийх, шагнаж урамшуулахдаа мэдэгдэл, тайлбар гаргадаггүй;

2/ хурал, зөвлөгөөн, сургалтад оролцсон талаарх тайлан, мэдээ, санхүүгийн тайланг олон нийтэд нээлттэй ил тод болгодоггүй;

3/ албан томилолтоор ирсэн хүмүүсийн хоолны зардалд төсвөөс хөрөнгө гаргасан;

4/ төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын дагуу цахим хуудсыг нээлттэй ил тод болгоогүй;

5/ Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар байгууллага, аж ахуйн нэгж хувь хүнтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан талаарх мэдээлэл нээлттэй ил тод биш; */жишээлбэл, "Ном хур" ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд нэг ном 29 700 төгрөгөөр хэвлүүлэх гэрээ байгуулсан бөгөөд Налайх дүүргийн төрийн байгууллагад 50 000 төгрөгөөр зарсан гэх, мэт/*

6/ Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 28 дугаартай тогтоолоор "Дүүрэг хөгжүүлэх сангийн дүрэм" баталж, хандив авсан ба уг сан нь компани, үйлдвэр аж ахуйн газар, байгууллага, ХЭАА, иргэдийн сайн дураар хандивласан хөрөнгө болон бусад орлогоос бүрдэхээр журамласан;

7/ "Дүүрэг хөгжүүлэх сан"-д альбом борлуулсны хөлс, сурталчилгааны самбарын төлбөр, хогны торгууль, ил задгай үйлчилгээ явуулах төлбөр, дэлгэцийн сурталчилгааны төлбөр, тамхины тусгай зөвшөөрөл, өвсний фонд бүрдүүлэх зэрэг орлогууд төвлөрүүлсэн;

8/ дүүрэг хөгжүүлэх санд хандив өгсөн аж ахуйн нэгж, иргэдтэй холбоотой шийдвэр гаргасан; */жишээлбэл, "Бум батын гол" ХХК, "Хун Хуа" ХХК, "Шаазгайтын нуруу" ХХК, "Молор жуулчин" ХХК, "Хан Тэрэлж" жуулчны бааз гэх, мэт/*

9/ Засаг даргын дэргэдэх агентлагуудаас хандив, санхүүгийн туслалцаа авсан Соёл урлагын ордон, Бүртгэлийн хэлтэс, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, өөрөө өөртэй

004649

тушаал шийдвэр гаргаж, шагнаж урамшуулсан Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Эрүүл мэндийн төв, Татварын хэлтэс, Хангамж үйлчилгээний төв, Гэрэлтүүлэг-Чимэглэлийн албаны удирдлагууд, Ерөнхий боловсролын 119 дүгээр сургуулийн захирал Ж.Батцэцэг, 109 дүгээр бага сургуулийн захирал Д.Цэрэндолгор, 123 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Долгорсүрэн, 152 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ж.Алтан-Од зэрэг байгууллага, албан тушаалтан болно.

Цаашид тус дүүрэгт дараах ажлуудыг нэн шаардлагатай авч хэрэгжүүлэх саналтай байна. Үүнд:

1/ эрх зүйн акт гаргах үндэслэлээ холбогдох хуулийн заалтад нийцүүлэх;

2/ нийтийн албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн бол үүссэн тухай тайлбарыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлж байх;

3/ төсвийн хөрөнгийг зохих хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зарцуулдаг байх, нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

4/ Налайх дүүргийн /www.nad.ub.gov.mn/ цахим хуудсыг нээлттэй ил тод болгох, тухай бүр цахим хуудасны мэдээллийн баяжилт хийх;

5/ албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс хуулиар зөвшөөрснөөс бусад бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах, хүсэхийг хориглох;

6/ хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой шийдвэр гаргахыг хориглох;


7/ гэрээ, хэлэлцээр хийсэн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод болгох;

8/ давхар ажил эрхлэлттэй холбоотой болон хамаарал бүхий этгээдийн ажил эрхлэлтийн нэгдсэн судалгааг дүүргийн хэмжээнд гаргаж, нээлттэй болгох зэрэг болно.

Иймд Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг чанд мөрдөж, дээр дурдсан зөрчил, дутагдлыг дахин гаргахгүйгээр ажиллах талаар дүүргийн Засаг даргын Тамгын газар, эрхлэх асуудлын хүрээний байгууллага, албан тушаалтнуудыг хамруулсан тодорхой арга хэмжээг зохион байгуулж дүнг 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хувийг: Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ